



**ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/124

Зуунмод

Орон нутгийн хамгаалалтын сургалт зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Дайчилгааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, Орон нутгийн хамгаалалтын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дах заалт, Засгийн газрын 2022 оны мн/306 дугаар тогтоол, Батлах хамгаалахын сайдын 2023 оны мн/21 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод сумын нутаг дэвсгэрт дайчилгааны даалгавраар оногдуулан бүртгэгдсэн бэлтгэл үүрэгтэн, орон нутгийн хамгаалалтын томилгоод нэгжид бодит тодотгол хийж, бэлтгэл үүрэгтнүүдтэй гэрээ байгуулах, Орон нутгийн хамгаалалтын сургалтыг зохион байгуулахад оролцох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | | |
|----------------------|--------------|--|
| Ажлын хэсгийн дарга: | Б.Отгонбаяр | -БаруунЗуунмод багийн Засаг дарга |
| Гишүүд | Ч.Цогтмягмар | -Захирагчийн албаны гэрээт төсөвчин |
| | О.Одням | -Байгаль орчны мэргэжилтэн |
| | Д.Амартүвшин | -Хууль эрх зүйн мэргэжилтэн |
| | Д.Өнөрбаяр | -Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн |
| | Г.Уянга | -Засаг даргын туслах, ИХМОНХАжилтан |
| | П.Бат-Аюуш | -Нярав |
| | | -Багийн Засаг дарга нар |
| | | -Зохион байгуулагч нар |
| | | -Хэсгийн ахлагч нар |


Нарийн бичгийн дарга: Т.Пансандулам -Архив бичиг хэргийн эрхлэгч

2.Сургалтыг аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас өгсөн чиглэл, хуваарийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Монгол туургатан театрт зохион байгуулах тул ажлын төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь гарган батлуулж, ажиллахыг Ажлын хэсэг (Б.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

3.Сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдах 595400 /Таван зуун ерэн таван мянга дөрвөн зуун/ төгрөгийг хавсралтаар баталж, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал болон бараа үйлчилгээний бусад зардлаас гаргаж зарцуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Батжаргал), нягтлан бодогч (С.Намшир)-т тус тус зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газар (Г.Батжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  ЦАРААНГЭРЭЛ



Зуунмод сумын Засаг даргын 2023 оны
04 дугаар сарын 04 -ний өдрийн
А/1624 дугаар захирамжийн хавсралт.

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
 ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

| № | Материалын нэр | Хэмжих нэгж | Тоо | Нэгжийн үнэ | Нийт дүн |
|----|-------------------|-------------|-----|-------------|----------|
| 1 | Кофены аяга | ш | 400 | 350 | 140000 |
| 2 | Нэг удаагийн аяга | ш | 500 | 100 | 50000 |
| 3 | Дижик | кг | 5 | 20000 | 100000 |
| 4 | Чихэр | кг | 1 | 22500 | 22500 |
| 5 | Чихэр | кг | 1 | 26000 | 26000 |
| 6 | Ус | ш | 15 | 1800 | 27000 |
| 7 | Липтэн цай | ш | 1 | 19600 | 19600 |
| 8 | Сахар | ш | 1 | 6300 | 6300 |
| 9 | Бал | ш | 40 | 800 | 32000 |
| 10 | Коровка | ш | 5 | 20000 | 100000 |
| 11 | Чихэр | ш | 4 | 18000 | 72000 |
| | Дүн | | | | 595400 |

ХЯНАСАН:
 НЯ-БО



С.НАМШИР

ТӨСӨВ ХИЙСЭН:
 АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА

Б.ОТГОНБАЯР